



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн  
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гаргасан нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 31,322,459 ширхэг энгийн хувьцааг 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 313,224,590 /гурван зуун арван гурван сая хоёр зуун хорин дөрвөн мянга таван зуун ер/ ширхэг болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК хувь нийлүүлсэн хөрөнгөө 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 69,823,292 /жаран есөн сая найман зуун хорин гурван мянга хоёр зуун ерэн хоёр/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж буйтай холбогдуулан компанийн нийт гаргасан хувьцааг 383,047,882 /гурван зуун наян гурван сая дөчин долоон мянга найман зуун наян хоёр/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулаам/-д тус тус үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК /Ц.Наранчанга/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

900279